



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2019 оны 6 сарын 14 өдөр

Дугаар 144

Улаанбаатар хот

Салбар бүртгэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.4, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5, Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын багц дүрэм”-ийн 01 дүгээр хавсралт “Даатгалын, даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг авах хүсэлт гаргахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт болон Даатгагч, даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлт”-ийн 4.2.12 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Даатгалын зуучлагч “Худалдаа хөгжлийн банк” ХХК-ийн хавсралтад дурдсан 3 салбарыг бүртгэсүгэй.

2. Салбарыг бүртгэсэнтэй холбогдуулан тусгай зөвшөөрлийн гэрчилгээнд тэмдэглүүлж, Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлж, холбогдох баримт бичгийг ажлын 15 хоногийн дотор Санхүүгийн зохицуулах хороонд ирүүлэхийг “Худалдаа хөгжлийн банк” ХХК /О.Орхон/-д үүрэг болгосугай.


3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Б.Ариунаа/-нд даалгасугай.

ДАРГА



С.ДАВААСҮРЭН

Санхүүгийн зохицуулах хорооны
2019 оны 6. дугаар сарын 14-ний
өдрийн 14-р тогтоолын хавсралт



Салбарын дэлгэрэнгүй мэдээлэл

№	Салбарын нэр	Салбарын хаяг, байршил	Удирдлагын мэдээлэл
1	Сонгинохайрхан дүүргийн “Авто худалдааны” салбар	Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 32-р хороо, Авто худалдааны цогцолбор ОНӨААТҮГ, Авто худалдааны цогцолбор төвд	Салбарын захирал Э.Мөнх-Од Утас: 99093019
2	Баянзүрх дүүргийн “Дүнжингарав” салбар	Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 26-р хороо, 13311 Нийслэл хүрээ өргөн чөлөө гудамж, 603-р байр, 1, 2 давхрын хэсэг тоот байршилтай байрны 2-р давхарт	Салбарын захирал О.Давааням Утас: 99105245
3	Хан-Уул дүүргийн “Ривер гарден” салбар	Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 11-р хороо, Стадион оргил /17012/, Их Монгол улс гудамж 603 тоот, Их Монгол плаза барилга 2-р давхарт	Салбарын захирал О.Мөнхцэцэг Утас: 99041241